



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд дулааны станц ТӨХК-ийн  
2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2025/002/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Ховд хот 2025 он	Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 70432545 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn Аудитор: Н. Батзул Утас: 98111917 Цахим хаяг: <a href="mailto:batzuln@audit.gov.mn">batzuln@audit.gov.mn</a>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.  
ХОА-2025/002/НА-СТА-ТӨҮГ



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

**ХОВД ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.ЭНХСАЙХАН  
ТАНАА**

*2025.03.15* № *2/106*

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### **Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Ховд дулааны станц ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### **Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Ховд дулааны станц ТӨХК нь 2024 онд 77,309.2 Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэж 76,212.5 Гкал дулааны эрчим хүчийг түгээж 65,303.5 Гкал дулааны эрчим хүчийг борлуулсан байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг 8,466.5 сая төгрөгийн зардалтай ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 7,622.9 сая төгрөгийн зардал санхүүжүүлэн 843.7 сая төгрөгийн хэмнэлттэй ажиллан өмнөх онуудын 1,179.6 сая төгрөгийн авлагаас 584.8 сая төгрөг барагдуулсан байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Ховд дулааны станц ТӨХК нь худалдан авах ажиллагааг зохион байгуулж 2,482.5 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээг худалдан авсан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	41,137,492.19	4,368,631.60
1.1.02	Дансны авлага	1,178,913,429.46	593,157,321.74
1.1.04	Бусад авлага	0.00	1,670,000.00
1.1.06	Бараа материал	1,123,100,055.95	1,468,915,762.29
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	745,000.00	0.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,343,895,977.60	2,068,111,715.63
1.2.01	Үндсэн хөрөнгө	10,702,487,576.40	10,647,903,165.11
1.2.02	Биет бус хөрөнгө	727,590,000.10	731,135,000.18
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	11,430,077,576.50	11,379,038,165.29
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	13,773,973,554.10	13,447,149,880.92
2.1.1.01	Дансны өглөг	1,452,331,753.88	652,412,762.53
2.1.1.03	Татварын өр	359,184,146.47	241,265,444.23
2.1.1.04	НДШ - ийн өглөг	169,019,611.78	807,424.92
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	5,230,351.00	10,686,816.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	14,526,834.49	3,936,398.03
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,000,292,697.62	909,108,845.71
2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,000,292,697.62	909,108,845.71
2.3.01	Өмч: - төрийн	13,640,526,161.23	13,640,526,161.23
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,156,971,401.82	1,156,971,401.82
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	695,420,000.00	695,420,000.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-3,719,236,706.57	-2,954,876,527.84
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	764,360,178.73
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-3,719,236,706.57	-3,719,236,706.57
2.3.11	Эздийн өмчийн дүн	11,773,680,856.48	12,538,041,035.21
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	13,773,973,554.10	13,447,149,880.92

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	4,995,453,576.11	5,719,416,240.03
02	Борлуулалтын өртөг	5,770,682,448.07	6,317,472,577.52
03	Нийт ашиг( алдагдал)	-775,228,871.96	-598,056,337.49
04	Түрээсийн орлого	0.00	0.00
05	Хүүний орлого	142,485.18	543,714.02
06	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
07	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00

Ховд дулааны станц ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

08	Бусад орлого	1,620,709,092.87	2,707,515,545.18
08.1	Орлогын дүн	1,620,851,578.05	2,708,059,259.20
09	Борлуулалт, маркетингийн зардал	304,860,731.45	344,522,418.01
10	Ерөнхий ба удирдлагын зардал	771,054,860.74	960,863,278.87
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	0.00	0.00
12.1	Зардлын дүн	1,075,915,592.19	1,305,385,696.88
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-1,423,916.86	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг ( алдагдал)	0.00	0.00
17.1	Олз, гарзын дүн	-1,423,916.86	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)	-231,716,802.96	804,617,224.83
19	Орлогын татварын зардал	0.00	40,257,046.10
19.1	Хойшлогдсон татварын зардал	0.00	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-231,716,802.96	764,360,178.73
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	-231,716,802.96	764,360,178.73
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	0.00	0.00
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	6,416,804,201.44	9,771,462,172.46
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	4,795,767,075.26	6,707,450,660.49
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	353,125.00	3,839,655.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	0.00	0.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	1,400,000,000.00	2,928,140,130.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	220,684,001.18	132,031,726.97
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,572,950,379.42	8,963,895,750.05
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,768,944,170.32	2,403,665,608.27
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	405,507,081.99	919,155,623.50
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	831,147,599.00	1,227,850,688.00

Ховд дулааны станц ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	658,804,014.59	1,461,631,250.58
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,561,648,806.30	2,045,352,253.53
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	326,905,667.22	874,358,695.74
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	2,469,565.00	3,000,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	17,523,475.00	28,881,630.43
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	843,853,822.02	807,566,422.41
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	0.00
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0.00	0.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	0.00	0.00
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
2.1.8	Бусад	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	677,341,959.00	844,335,283.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	677,341,959.00	844,335,283.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0.00	0.00
2.2.6	Бусад	0.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-677,341,959.00	-844,335,283.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.3	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
3.1.4	Бусад	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	140,000,000.00	0.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	80,000,000.00	0.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	0.00	0.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	60,000,000.00	0.00

Ховд дулааны станц ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

3.2.5	Бусад	0.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-140,000,000.00	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	26,511,863.02	-36,768,860.59
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14,625,629.17	41,137,492.19
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	41,137,492.19	4,368,631.60

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	13,640,526,161.23	1,156,971,401.82	695,420,000.00	-3,487,519,903.61	12,005,397,659.44
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00
03	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-231,716,802.96	-231,716,802.96
05	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
06	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
07	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
09	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	13,640,526,161.23	1,156,971,401.82	695,420,000.00	-3,719,236,706.57	11,773,680,856.48
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00
11	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	764,360,178.73	764,360,178.73
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
15	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
17	2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл	13,640,526,161.23	1,156,971,401.82	695,420,000.00	-2,954,876,527.84	12,538,041,035.21

2.5 Аудит хийсэн эдийн засгийн зорилтот түвшний тайлан

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2023 оны гүйцэтгэл	2024 он		Харьцуулалт өссөн/+, буурсан/-			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2023 оны гүйцэтгэлтэй		Төлөвлөгөөтэй	
						Тоо	хувь	Тоо	хувь
1	1.1 Үйлдвэрлэсэн ДЭХ	Гкал	71,170.2	83,795.3	77,309.2	6,138.9	8.6	6,486.1	7.7
	1.2 Дотоод хэрэгцээний дулааны эрчим хүч	Гкал	842.2	1,159.1	1,096.6	254.5	30.2	62.4	5.4
		хувь	1.2	1.4	1.4	0.2	19.9	0.0	2.6
	1.3 Түгээсэн ДЭХ	Гкал	70,328.1	82,636.2	76,212.5	5,884.4	8.4	6,423.7	7.8
	1.4 Шугамын алдагдал	Гкал	14,401.0	12,064.9	10,909.0	3,491.9	24.2	1,155.8	9.6
1.5 Борлуулсан ДЭХ	Гкал	55,927.1	70,571.3	65,303.5	9,376.3	16.8	5,267.8	7.5	
2	Нийт орлого	сая.төг	6,616.3	7,049.5	8,427.5	1,811.2	27.4	1,378.0	19.5
	Үүнээс:Борлуулалтын орлого	сая.төг	4,995.5	5,549.1	5,719.4	724.0	14.5	170.3	3.1
	Үйл ажиллагааны бусад орлого	сая.төг	529.9	227.7	273.4	256.6	48.4	45.7	20.1
	Санхүүжилт (татаас)	сая.төг	1,090.9	1,272.7	2,434.7	1,343.8	-	1,161.9	91.3
3	Нийт зардал	сая.төг	6,848.0	8,466.5	7,622.9	774.8	11.3	843.7	10.0
	Үүнээс:Үйл ажиллагааны зардал	сая.төг	6,846.6	8,466.5	7,622.9	776.3	11.3	843.7	10.0
	Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	1.4	-	-	1.4	-	-	-
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/	сая.төг	231.7	-1,417.0	804.6	1,036.3	447.2	2,221.6	156.8
5	Цэвэр ашиг, алдагдал	сая.төг	231.7	-1,417.0	764.4	996.1	429.9	2,181.4	153.9
6	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төгрөг	1.0	1.2	0.90	0.1	12.6	0.3	24.7
7	Нийт авлага	сая.төг	1,179.7	380.0	594.8	584.8	49.6	214.8	56.5
	Үүнээс: ЭХ-ний авлага	сая.төг	1,146.0	380.0	565.0	581.0	50.7	185.0	48.7
	Бусад авлага	сая.төг	33.7	-	29.8	3.9	11.5	29.8	-
8	Нийт өр төлбөр	сая.төг	2,000.3	840.0	909.1	1,091.2	54.6	69.1	8.2
	Үүнээс: Богино хугацаат	сая.төг	2,000.3	840.0	909.1	1,091.2	54.6	69.1	8.2
	Урт хугацаат өр төлбөр	сая.төг	-	-	-	-	-	-	-
9	Хөрөнгө оруулалт их засвар ТЗБАХ	сая.төг	490.4	744.8	741.3	250.9	51.2	3.5	0.5
10	Жишмэл түлшний хувийн зарцуулалт ДЭХ	кг.гкал	278.5	269.5	281.3	2.8	1.0	11.8	4.4
11	Нийт ажиллагсдын тоо	хүн	106.0	108.0	106.0	-	-	2.0	1.9
12	Нийт цалингийн сан	сая.төг	2,081.3	2,859.6	2,805.1	723.8	34.8	54.5	1.9

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 6,134.0 мянган төгрөгийн 2 алдаа, зөрчил илэрч баталгаажуулав.

**Ховд дулааны станц ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Ховд дулааны станц ТӨХК													
Дүн													

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Ховд дулааны станц ТӨХК	1	6.1					1	6.1				
	1	0					1	0				
Дүн		6.1						6.1				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	0	0	1	0	0	0
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>